КРЕДИТ
ББСБ

2022 ЖИЛИЙН ТАЙЛАН

Агуулга

01

Гүйцэтгэх удирдлагын илгээлт 04

Эрхэм зорилго 07
Алсын хараа 07
Үнэт зүйлс 07

02

Компанийн тухай 08

Түүхэн замнал 09
2022 оны онцлох үйл явдал 10
2022 оны гол үзүүлэлтүүд 11
Зээлийн үйл ажиллагаа 12
Санхүүгийн гол үзүүлэлтүүд 13
Тогтвортой санхүүжилт 14
Нийгмийн хариуцлага 14
Эрсдэлийн удирдлага 15
Хүний нөөц 17
Удирдлагын багийн танилцуулга 18
Компанийн бүтэц, зохион байгуулалт 20

03

Финтект суурилсан үйлчилгээ 22

Ард Апп 24
АрдКидс 25
Цахим зээл 26
Cupcake 26
Pick n Pay 27
GOOD платформ /СКОПА төсөл/ 27

04

Компанийн засаглал 28

Хувьцаа эзэмшигчдийн хурал 30
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц 30
Хувьцааны арилжаа 31

05

Төлөөлөн Удирдах Зөвлөл 32

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн 34
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны шийдвэрлэсэн асуудлууд 36
Төлөөлөн Удирдах Зөвлөл ийн хороодын чиг үүрэг, шийдвэрлэсэн асуудлууд 36

06

Хараат бус аудитын тайлан 38

Хамтрагч байгууллагууд 41

Гүйцэтгэх удирдлагын илгээлт

Эрхэм хүндэт Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагсад, харилцагч танаа

Г.Тэлмэн

Бид 2022 оныг эдийн засгийн тодорхойгүй бөгөөд хүндрэлтэй нөхцөлд өндөр ачаалал, амжилт бүтээл дүүрэн ардаа үлдээлээ. 2022 он бидний хувьд 2021 оны үлэмж их өсөлтийг хадгалж үлдэх, цаашид тогтвортой өсөлт үзүүлэх зорилт тавин ажилласан жил байлаа.

Ард Кредит ББСБ ХК олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноос хойш жил бүр Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс болон I ангилалд орж ирсэн уламжлалт амжилтаа хадгалсан төдийгүй хувьцаа эзэмшигчдийн тоогоо хэвээр хадгалж үлдлээ. 2022 оны туршид 1.3 тэрбум төгрөгийн 10.0 сая ширхэг компанийн хувьцаа арилжаалагджээ.

Компанийн үндсэн үйл ажиллагааны хувьд зээлийн багцаа 36.6 тэрбум төгрөгөөс 41.8 тэрбум төгрөгт хүргэж, зээлдэгчийн тоогоо 47.7 мянгаас 50.4 мянга болгон, хүү, шимтгэлийн орлого 9.9 тэрбум төгрөгөөс 14.6 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлж, 2.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

Өнгөрөгч онд бодлогын хүү 5 удаа нэмэгдэж, банк санхүүгийн байгууллагууд зээл олголт, санхүүжилтээ хумьж байх үед бид харилцагчидтайгаа илүү ойр байж зээл олголтоо хэвийн түвшинд үргэлжлүүлж, компанийн цаашдын үйл ажиллагааны өргөжин тэлэлтэд онцгой анхаарал хандуулан, шинэ төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олголлоо.

2022 онд Ард Кредит Монгол улсад анх удаа үйлдвэрлэгч, нийлүүлэгч, бизнес эрхлэгч, эцсийн хэрэглэгчийг холбосон нийлүүлэлтийн гинжин хэлхээний шинэ төрлийн санхүүжилтийн үйлчилгээ болох СКОПА төслийг хэрэгжүүлж, малчдад зориулан хөнгөлөлттэй зээл, харилцагч нартаа зориулан Pick n Pay хүүгүй, шимтгэлгүй худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүн, Cupcake гүйлгээ бүрээсээ хуримтлал үүсгэх боломжтой бүрэн цахимжсан хуримтлалын үйлчилгээг Ард Аппад нэвтрүүлэв.

Нийгмийн хариуцлага, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах ажлын хүрээнд ToC (Тогтвортой Санхүүжилтийн Холбоо)-нд нэгдэж, #БидИлүүБайжЧадна аяныг хэрэгжүүлж Монгол улсын хүүхэд бүрийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болгох шийдвэрийг гаргалаа.

Оны төгсгөлд Монголбанкнаас карт гаргагчийн тусгай зөвшөөрөл авсан нь 2017 онд салбартаа анхлан кредит карт гаргаж байсантай адил салбартаа анхдагч карт гаргагч боллоо. Тун удахгүй цоо шинэ Ардын кредит картыг хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

Бид компанийн 2023-2025 оны буюу дунд хугацааны зорилтыг шинэчлэн боловсруулж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ харилцагчид, олон нийтэд илүү хүртээмжтэй үзүүлэх зорилгоор хүн болон технологийн хосолмол Phygital хэлбэрийг хөгжүүлэн ажиллаж байна.

2023 онд бид илүү шинийг эрэлхийлж, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдадаа өндөр өгөөж хүртээж, харилцагчдадаа олон олон таатай, хэрэгцээг нь бүрэн хангахуйц бүтээгдэхүүн үйлчилгээ, боломжийг нэвтрүүлж, салбараа манлайлан ажиллана гэдэгт итгэлтэй байна. Танд сайн сайхныг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал

Г.Тэлмэн

Алсын хараа

Ирээдүйн ур чадвар, технологийг цаг хугацааны товчлолоор авчирч, тогтвортой хөгжлийг түргэтгэж, өндөр өгөөжийг бий болгоно

Эрхэм зорилго

Салбарын хөгжлийг түүчээлнэ.

Үнэт зүйлс

Хамтдаа хуваалцах
Тогтвортой хөгжих
Хүлээлтээс давж үйлчлэх
Хүртээмжтэй, тэгш оролцоог бүрдүүлэх
Ёс зүйтэй байх



Компанийн тухай

02

2011

Интергрупп Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар байгуулагдав

2017

Салбартаа анхлан Кредит картын үйлчилгээг амжилттай нэвтрүүлэв.

2018

Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороноос IPO хийх зөвшөөрөл авч үнэт цаасаа бүртгүүлэв.

Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх Ард Аппын анхны хувилбарыг олон нийтэд танилцуулав.

2019

Хиймэл оюун ухаанд суурилсан цахим зээлийн үйлчилгээг Ард Аппаар дамжуулан олгож эхлэв.
1,500 гаруй шинэ хувьцаа эзэмшигчтэй олон нийтэд нээлттэй хувьцаат компани болов.
Монголын Хөрөнгийн Биржийн хувьцаат компанийн I ангилалд дэвшин оров.

2020

Монголбанкнаас Ард Кредит ХК-д Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосноор банкны төлбөр тооцооны үйлчилгээнд оролцож эхлэв.
EuroGiro олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг Монгол Шуудан ХК-тай хамтран нэвтрүүлж, харилцагчдадаа дэлхийн 56 улсаас хамгийн бага шимтгэлтэй мөнгөн гуйвуулга хийх боломжийг нээв.
ACH+ (Автомат Клиринг Хаус) банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг амжилттай нэвтрүүлэв.

2021

Анхны виртуал хөрөнгө барьцаалсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв.

Хүүхдэд зориулсан анхны санхүүгийн аппликейшн АрдКидс Аппыг зах зээлд нэвтрүүлэв.

2022 оны онцлох үйл явдал

- Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс болон Монголын Хөрөнгийн Биржийн Хувьцаат компанийн I ангилалд дахин багтав.
- Нийлүүлэлтийн гинжин хэлхээний СКОПА төслийг хамтран хэрэгжүүлж, төслийн хүрээнд малын тэжээлийн зээл, мерчантын зээлийн үйлчилгээг шинээр нэвтрүүлэв.
- 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 4.5 төгрөг буюу нийт 1.26 тэрбум төгрөгийг 13,419 хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр тараав.
- Хиймэл оюун ухаанд суурилсан цахим зээлийн үйлчилгээг Ард Аппаар дамжуулан олгож эхлэв.
- 1,500 гаруй шинэ хувьцаа эзэмшигчтэй олон нийтэд нээлттэй хувьцаат компани болов.
- Монголын Хөрөнгийн Биржийн хувьцаат компанийн I ангилалд дэвшин оров.
- Ард Аппад ДАН системийг нэвтрүүлэв.
- Тогтвортой Санхүүжилтийн холбоонд нэгдэв.
- "Хөрөнгө оруулагч үндэстэн чуулган-2022", Хувьцаа эзэмшигчдийн хурлыг амжилттай зохион байгуулав.
- Pick n Pay /BNPL/ худалдан авалтын зээлийн үйлчилгээг Ард Аппад нэвтрүүлэв.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн-ийн даргаар Ч.Ганзориг томилогдов.
- Гүйлгээ бүрээс хуримтлал үүсгэх "CupCake - Хариултаа хадгал" хуримтлалын үйлчилгээг нэвтрүүлэв.
- 7 тэрбум төгрөгийн хаалттай бонд гаргах зөвшөөрөл авч, амжилттай татан төвлөрүүлэв.
- #БидИлүүБайжЧадна аяныг хэрэгжүүлж АрдКидс Аппад бүртгэлтэй 40,000 хүүхдийг эгнээндээ нэгтгэж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болгов.
- 5 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөг гаргах зөвшөөрөл авав.
- ББСБ-уудаас анх удаа карт гаргагчийн зөвшөөрөл авав.

2022 оны гол үзүүлэлтүүд

- Хувьцаа эзэмшигчийн тоо - 13,539
- Харилцагчийн тоо - 1,019,392
- АрдКидс харилцагчийн тоо - 37,440
- Апп таталт - 272,905
- Зээлийн багц - 41.8 тэрбум төгрөг
- Олгосон зээлийн дүн - 95.0 тэрбум төгрөг
- Зээлдэгчийн тоо /өссөн дүнгээр/ - 50,459
- Зээлийн хүсэлт - 595,115
- Нийт хөрөнгө - 58.1 тэрбум төгрөг
- Санхүүжилт - 32.5 тэрбум төгрөг
- Итгэлцэл - 13.5 тэрбум төгрөг
- Цэвэр ашиг - 2.1 тэрбум төгрөг



Зээлийн үйл ажиллагаа

2022 онд нийт 95 тэрбум төгрөгийн дүнтэй 46,851 удаагийн зээлийг иргэн, аж ахуйн нэгжид олгосон нь өмнөх оны мөн үеэс 12 хувиар өссөн байна. Нийт зээлийн багц 2021 оны эцэст 36.6 тэрбум төгрөг байсан бол 2022 онд зээл олголтыг нэмэгдүүлснээр 14 хувиар өсөж 41.8 тэрбум төгрөгийн багцад хүрэв.

#	Үзүүлэлт /сая төгрөг/	2021	2022	Өсөлтийн хувь
1	Олгосон зээлийн тоо	65,756	65,756	(29%)
2	Олгосон зээлийн дүн	84,991	84,991	12%
3	Нийт зээлийн багц	36,646	36,646	14%
4	PAR%	9.2%	9.2%	44%
5	NPL%	7.02%	7.02%	11%
6	Нэг зээлийн дундаж үлдэгдэл	1.57	1.57	69%
7	Зээлийн эргэн төлөлт /үндсэн зээл/	68,668	68,668	31%
8	Зээлийн хүсэлтийн тоо	785,741	785,741	(24%)
9	Зээлийн жигнэсэн дундаж хүү	34.9%	34.9%	(8%)

Санхүүгийн гол үзүүлэлтүүд /сая төгрөг/





Цэвэр зээл



2020	2021	2022
18,949	34,178	40,038

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



2020	2021	2022
18.7%	14.3%	12.7%

Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа



2020	2021	2022
0.9%	1.6%	1.6%

Чанаргүй зээл



2020	2021	2022
9.5%	7.0%	7.8%

Өрийн харьцаа



2020	2021	2022
62.0%	69.2%	68.8%

Цэвэр ашиг



2020	2021	2022
1,241	3,925	2,106

Тогтвортой санхүүжилт

Бид тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаанд нэгдэж Монголын тогтвортой санхүүжилтийн холбоонд үндсэн гишүүнээр элсэн орлоо. Компанийн дунд хугацааны стратеги, 2023 оны бизнес төлөвлөгөөнд тогтвортой санхүүжилтийг үе шаттайгаар үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр тусгасан бөгөөд 2022 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн бодлогоо баталж, зээлийн үйл ажиллагаандаа Байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээг хийж эхлээд байна.

Тогтвортой санхүүжилтийн хүрээнд ногоон зээлийн бүтээгдэхүүн гаргах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй эко бизнесийг дэмжин ажиллах, үйл ажиллагаандаа ToC-ын 8 зарчмыг мөрдлөг болгон хэрэгжүүлж, хүний эрхийн мэдрэмжтэй, хүртээмжтэй ажлын байрыг бий болгон бизнесийн үйл ажиллагаагаараа дамжуулан тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахаар зорилго тавин ажиллаж байна.

Нийгмийн хариуцлага

Хөрөнгө Оруулагч Үндэстэн, Хувьцаа Эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн 573 хүүхдэд компанийнхаа 10 ширхэг хувьцааг бэлэглэж, 2022 оны 6 сарын 1-ний өдөр Хүүхдийн баяраар Хүүхдийн ертөнц 2022, Momento 1,000 ээжийн арга хэмжээг ивээн тэтгэж, хамтран ажиллав.

#БидИлүүБайжЧадна аяныг хамтран хэрэгжүүлж аяны хүрээнд Ардын бүрэлдэхүүн компаниудын ажиллагсдын 1,309 хүүхдэд 10 ширхэг Ард Санхүүгийн Нэгдэл ХК (MSE:AARD)-ийн 5 ширхэг хувьцааг олгож, Монгол Улсын нийт хүүхдүүдэд 3 ширхэг хувьцаа олгох хөдөлгөөнийг эхлүүлэв. Мөн Ард Кредит ББСБ ХК (MSE:ADB)-ийн хувьцаа эзэмшигчдийн хүүхдүүдэд АрдКойн урамшууллаар олгов.

Эрсдэлийн удирдлага

Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, бусад оролцогч талууд нь бидний бизнест үүсэх эрсдэлд шууд болон шууд бусаар өртөх боломжтой байдаг тул бидний зүгээс хариуцлагын хүрээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог алба, нэгж бүртээ бүрдүүлэн ажиллаж ирсэн. Байгууллагын дотоод соёл, үүр амьсгал нь нийт ажиллагсдын зан төлөв хандлагыг төлөвшүүлдэг. Энэ нь ажиллагсад эрсдэлд хэрхэн хандах, ямар хэмжээний эрсдэл хүлээн зөвшөөрөх, эрсдэлийг хэрхэн удирдах зэрэгтэй шууд хамааралтай. Тиймээс бид байгууллагын соёлдоо ажилтан нэг бүр эрсдэлийн удирдлагад хариуцлагатай хандаж, өөрсдийн ажлын дээрх эрсдэл нэг бүрийг тооцоолон ажиллах хэв маягийг бүрдүүлж ажиллаж байгаа билээ.

Бид тулгарч болзошгүй эрсдэлүүдийг макро эдийн засаг, бодлогын хүүгийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон зээлийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, тусгай зөвшөөрлийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны шаардлага, Монгол банкны бодлогын хүрээ, мэдээллийн аюулгүй байдал, кибер халдлага, бизнесийн салбарын орчин, санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэхэд үүсэж болзошгүй эрсдэл зэргээр эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, багасгах арга хэмжээнүүдийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлж байна.

“Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого”-ын хүрээнд эрсдэл хариуцсан албан тушаалтан болон баг хамт олон нь эрсдэлийн удирдлага, хяналт, үнэлгээ, шугаман мэдээлэл, авсан зохистой арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилладаг. Хяналт, үнэлгээний ажил нь тасралтгүй үнэлгээ, салангид буюу давтамжит үнэлгээ эсхүл хосолсон үнэлгээ гэж ангилан тасралтгүй тайлагнах байдлаар хэрэгжүүлдэг. Компанийн эрсдэлийн хамгаалалтын шугамын хүрээнд ажиллагсад дараах байдлаар эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн талаар тайлагнаж байна.

Эрсдэлийн хамгаалалтын түвшин	Хэрэгжүүлэгчид	Тайлагнах эрх бүхий албан тушаалтан	Тайлагнах хугацаа
Эрсдэлийн хамгаалалтын 1-р түвшин;	Харилцагчийн үйлчилгээний төвийн ажилтан, Зээлийн мэргэжилтэн, Эрсдэлийн мэргэжилтнүүд;	Харилцагчийн үйлчилгээний төвийн ажилтан, Зээлийн мэргэжилтэн, Эрсдэлийн мэргэжилтнүүд;	7 хоног тутамд, эрсдэлийн далайц их тохиолдолд нэн даруй;
Эрсдэлийн хамгаалалтын 2-р түвшин;	Зээл эрхэлсэн захирал, Ерөнхий нягтлан бодогч, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Санхүүгийн менежер, Маркетингийн менежер, Хуульч, Комплаенс хариуцсан ажилтан;	Гүйцэтгэх захиралд;	Гүйцэтгэх захиралд 7 хоног тутамд, эрсдэлийн далайц их тохиолдолд нэн даруй
Эрсдэлийн хамгаалалтын 3-р түвшин;	Дотоод аудитор, Эрсдэл хариуцсан захирал	Дотоод аудитор, Эрсдэл хариуцсан захирал	Гүйцэтгэх захиралд 7 хоног тутамд, эрсдэлийн далайц их тохиолдолд нэн даруй, ТУЗ-д улирал тутамд;

Бид санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, тасралтгүй тогтвортой өсөлтийг хангах зорилгоор дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн томоохон аудит, зөвлөх үйлчилгээний байгууллага болох Грант Торнтон-оос 3 дахь жилдээ эрсдэлд суурилсан хөндлөнгийн аудитын шалгалт оруулж, дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу финтек зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй компанийн зүгээс Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болох олон улсын ISO27001 стандартыг нэвтрүүлэх ажлыг 2022 оны 4-р улирлаас эхлэн итгэмжлэгдсэн Инфосек компанийн тусламжтайгаар хэрэгжүүлэлтийн ажлыг хийж байна. Тухайн стандарт нь өөрийн мэдээллийн хөрөнгөнд учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, тухайн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцаар хангах юм. Мөн нийт ажиллагсдын хүрээнд давтамжтайгаар танхим болон цахим "эрсдэл-боломж" ойлголт, эрсдэлийг олж илрүүлэх, үнэлгээ хийх сургалтуудыг зохион байгуулж компанийн ажилтан тус бүрийн оролцоотой эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бид дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг компанийн засаглалын хүрээнд ТУЗ-н дэргэдэх Санхүү, зээл, эрсдэлийн хороонд цаг алдалгүй тайлагнан хэлэлцэж хариу арга хэмжээг тухай бүрд авч ажиллаж байна. Мөн толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн эрсдэлийн хороо, чадварлаг мэргэжилтнүүдийн зөвлөгөө мэдээллээр хангагдан эрсдэлийн удирдлагыг стратегийн түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүний нөөц

Хүйсээр



- Нийт ажилтан 30
- Гэрээт ажилтан 1
- Тусгай хэрэгцээт ажилтан 1
- Дундаж нас 34
- Эрэгтэй ажилтан 10
- Эмэгтэй ажилтан 20

2022 онд ажлын цагийг уян хатан болгож, 08:00 - 10:00 цагийн хооронд ирэх, 17:00 - 19:00 цагт тарах, ажлын өдрүүдэд зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлж, ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг дээд зэргээр ханган ажиллах, тэгш эрхийн бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажиллалаа.

Компанийн ажилтан бүрийг ₮20,000,000 нөхөн төлбөр бүхий эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулж, ажиллагсдадаа өөрийн болон бүрэлдэхүүн компаниудын хувьцаа, виртуал хөрөнгийг урт хугацаанд эзэмшүүлэх, ажилтнаас болон байгууллагаас сар бүр тэтгэврийн хуримтлалд орлого нэмэх зэрэг ажилтны болон тэдний гэр бүл, үр хүүхдийн ирээдүйд тасралтгүй хөрөнгө оруулалт хийж ажилласаар байна.

Удирдлагын багийн танилцуулга

Г.Тэлмэн

Гүйцэтгэх Захирал

Г.Сүхбаатар

Бизнес хөгжил эрхэлсэн захирал

М.Номин-Эрдэнэ

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

Б.Баттөгс

Зээл эрхэлсэн захирал

Х.Билгүүн

Санхүү эрхэлсэн захирал

Г.Чимэгсүрэн

Байгууллага, хамтын ажиллагаа эрхэлсэн захирал

Компанийн бүтэц, зохион байгуулалт




Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо
Дотоод аудитор
Ард Санхүүгийн Нэгдэл
Технологийн алба
Үйл ажиллагааны алба
Эрсдэлийн алба
Кластерийн удирдлага
Санхүүгийн удирдлага
Эрсдэлийн удирдлага
Борлуулалт, Маркетинг
Мэдээллийн технологи
Харилцагчийн үйлчилгээ

Финтект суурилсан үйлчилгээ

Ард Апп

Санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээг Ард Аппаар дамжуулан 24/7 горимоор үзүүлж байна. Үүнд:

- Бүх төрлийн төлбөр тооцоо, гүйлгээ
- Цахим зээл
- Урт болон богино хугацаат хуримтлалын үйлчилгээнүүд
- Онлайн дэлгүүр
- Үнэт цаас
- Даатгал



Харилцагчийн тоо	**1,019,392**
Апп таталт	**269,339**
Дундаж зээл олголт	**945,600 төгрөг**

АрдКидс

Хүүхдийн санхүүгийн хэрэглээг цогц хангасан Монголын анхны хүүхдэд зориулсан аппликейшн юм. 2022 онд АрдКидс Аппад Ирээдүйн Эзэн хүүхдийн хадгаламж, аав ээжээсээ утасны дугаараар дамжуулан АрдКойн хүлээн авах, гадаад улсад амьдарч буй хүүхдүүд утасны дугаараар дамжуулан бүртгүүлэх, найзаа урьж АрдКойн цуглуулах боломжийг нэвтрүүллээ. Мөн хүртээмжтэй байдал талаас аав ээж нь хүүхдээ утасны дугаараас гадна регистрийн дугаараар бүртгүүлэн урамшуулалт хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг нээлээ.

#БидИлүүБайжЧадна аяны хүрээнд Монгол улсын бүх хүүхдийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болгохоор ажиллаж байна.



Харилцагчийн тоо	37,440

Цахим зээлийн үйлчилгээ

Цаас хэмнэлт - 31.5 тонн

Мод хэмнэлт - 11,003ш мод

Салбаргүй бодлого хэрэгжүүлснээр

Эрчим хүчний хэмнэлт - 2,160,000 кВт (жилд)

Цаг хугацааны хэмнэлт - 104 жил буюу 911,040 цаг

CupCake - Хариултаа хадгал

CupCake нь хуримтлалын цоо шинэ төрлийн үйлчилгээ бөгөөд бүрэн автоматажсан гэдгээрээ онцлог юм. Харилцагч гүйлгээ хийх бүртээ ₮100, ₮1,000, ₮5,000, ₮10,000 гүйлгээний дүнгээ бүхэлчилж хуримтлалдаа орлого нэмэх боломжтой юм.

Ард Аппад нэвтэрсэн: 2022.10.05
Харилцагч: 875
Хуримтлал: 63 сая төгрөг

Pick n Pay

Pick n Pay нь Хүүгүй, шимтгэлгүй, хуваан төлөх боломжтой худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүн бөгөөд худалдан авсан бараа бүтээгдэхүүнийг дэлгүүрийн үнээр 60 хоногт 3-5 удаа хуваан төлөх боломжтой юм. Мөн худалдан авалт бүрийг үнийн дүнгийн 1%-тай тэнцэх АрдКойноор урамшуулна.

Ард Аппад нэвтэрсэн: 2022.05.01
Харилцагч байгууллага: 86
Салбар нэгж: 160

GOOD платформ

СКОПА төслийн хүрээнд хийгдэж буй GOOD платформ нь Худалдаа, үйлчилгээний байгууллагын бараа материал захиалах, хүлээн авах, тэдгээр үйл ажиллагаатай холбоотой бүртгэл тооцооны асуудлуудыг технологид суурилан цогцоор шийдвэрлэн, бизнес эрхлэгчдэдээ хүртээмжтэй, өртөг багатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зорилготой санхүүжүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, мерчант, эцсийн хэрэглэгчийн холбосон нийлүүлэлтийн гинжин хэлхээний цогц платформ бөгөөд Ард Кредит ББСБ ХК нь энэ төсөлд санхүүжүүлэгчээр оролцсон юм.

Төслийг хэрэгжүүлэхдээ томоохон нийлүүлэгч, үндэсний үйлдвэрлэгч Гацуурт ХХК эх орны хөрсөнд тарьж ургуулсан рапсын ургамлыг сонгож, Майндтэч ХХК-д эцсийн бүтээгдэхүүн боловсруулах хүртэлх бүхий л шатанд нийт 18.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай хийв. Майндтэч ХХК нь стратегийн бүтээгдэхүүн болох ургамлын тос, малын тэжээлийг үйлдвэрлэснээр нийт борлуулалт 21.8 тэрбум төгрөгт хүрч, нийт санхүүжилтээс 11.6 тэрбум төгрөг төлсөн амжилттай ажиллаж байна.

2022 онд уг төслийн хүрээнд GOOD платформд 15 нийлүүлэгч, 2,288 мерчант элсэж, нийт 1.1 тэрбум төгрөг /1,072,395,854/ борлуулалт хийгдсэн байна.

Үүнд:
Тосны борлуулалт: 177,836,448 төгрөг
Тэжээлийн борлуулалт: 828,312,356 төгрөг
Бусад борлуулалт: 66,247,050 төгрөг

Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Ард Кредит ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны I ангилалд 2021 оны 08 сарын 30-ны өдрөөс эхлэн багтсан бөгөөд 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр 2,139 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 13,539 хувьцаа эзэмшигчтэй байна.
Ард Кредит ББСБ ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөө цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл удирддаг.
Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах, компанийн хэлбэрийг өөрчлөх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг.
Компани 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай зохион байгуулж, 81.34 хувийн ирцтэйгээр хуралдан Ард Кредит ББСБ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, хоёрдогч өглөг гаргах, давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэрийг тус тус гаргалаа.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

#	Үзүүлэлт /сая төгрөг/	2022.12.31	Хувь
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	113,660,996	40.59%
2	С.Гэрэлтуяа	27,305,402	9.75%
3	Ардын Тэтгэврийн Данс ХХК	16,232,767	5.80%
4	Х.Батхишиг	14,426,999	5.15%
5	С.Оргил	11,658,223	4.16%
6	Г.Бат-Эрдэнэ	11,648,223	4.16%
7	Ард Бит ХХК	11,217,378	4.01%
8	Н.Мөнхнасан	7,058,824	2.52%
9	Эйч Ви Эл Эл ХХК	6,923,259	2.47%
10	А.Сүхдорж	5,086,580	1.82%
11	**Топ хувьцаа эзэмшигчид**	**25,218,651**	**80.44%**
12	Бусад хувьцаа эзэмшигчид	54,781,349	19.56%
13	**Эргэлтэнд байгаа хувьцаа**	**280,000,000**	**100.00%**
14	**Нийт зарласан хувьцаа**	**280,000,000**	**100.00%**
15	**Хувьцаа эзэмшигчдийн тоо**	**13,539**	

Хувьцааны арилжаа

Хаалтын ханш	128.7 төгрөг
Дээд болон доод үнэ	88-215 төгрөг
Нийт эргэлтэнд байгаа хувьцааны тоо	279,753,341
Нийт арилжааны дүн	1.3 тэрбум төгрөг
Зах зээлийн үнэлгээ	36.1 тэрбум төгрөг
Арилжаалагдсан хувьцааны тоо	10.0 сая ширхэг
EPS (TTM)	7.5 төгрөг
P/E (TTM)	17.1x
P/B	2.0x



Төлөөлөн Удирдах Зөвлөл

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн стратегийг тодорхойлж, хянах, үйл ажиллагааны тайлан батлах, Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах үүднээс шийдвэр гаргах, жилийн төсөв бизнес төлөвлөгөөг батлах зэрэг Компанийн тухай хууль, болон дүрэмд заасан чиг үүргийнхээ хүрээнд шийдвэр гаргаж ажилладаг. Мөн Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-т заасны дагуу Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Уудирдах Зөвлөл нь 11 хүртэл гишүүнтэй байхаар дүрэмдээ тусгаж, ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Чулууны Ганзориг

ТУЗ-ийн Дарга

Одончимэдийн Одбаяр

Ердийн гишүүн

Гэрэлтийн Тэлмэн

Ердийн гишүүн

Галнямын Уянга

Ердийн гишүүн

Батбилэгийн Золбоо

Ердийн гишүүн

Барамсайн Ганбат

Хараат бус гишүүн

Батсүрэнгийн Солонго

Хараат бус гишүүн

Ванчигийн Ганзориг

Хараат бус гишүүн

Сүхбаатарын Энхчимэг

Хараат бус гишүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны шийдвэрлэсэн асуудлууд

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 онд нийт 12 удаагийн ээлжит болон ээлжит бус хурал, 30 эчнээ санал хураалтаар 45 асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. 2022 онд шийдвэрлэсэн томоохон ажлуудаас дурдвал:

- 2022.02.18 2021 оны цэвэр ашгийн дүнгээс 30% буюу 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгох
- 2022.3.17 Хаалттай бонд гаргах
- 2022.3.18 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4 сарын 30-ны өдөр зохион байгуулав
- 2022.3.29 Кредит карт гаргах
- 2022.6.20 ТУЗ-ийн даргаар Ч.Ганзориг томилогдов
- 2022.6.20 Ёс зүйн дүрэм батлав
- 2022.12.15 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулахаар шийдвэрлэв.

ТУЗ-ИЙН ЦАЛИНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ /УРАМШУУЛЛЫН БҮТЭЦ/

2022 онд Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах төсөвтэйгөөр ажиллаа. Үүнд:

Төсөв	нэгж /төгрөг/	нийт дүн /төгрөг/
ТУЗ-ийн гишүүдийн цалин	7,800,000 /сард/	93,600,000
Хурлын бэлтгэл	150,000 /улиралд 1 удаа/	600,000
Бусад	200,000 /улиралд 1 удаа/	800,000
Нийт зардал		95,000,000

Урамшууллын бодлого

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгохдоо тухайн жилийн ажлын гүйцэтгэл 50%, хурлын ирц 50% тооцож жилд нэг удаа урамшуулал олгодог.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороодын чиг үүрэг

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэжлийн түвшинд удирдах зорилгоор Дотоод аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, зээлийн хороодтой байх бөгөөд уг Хороод нь Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-өөр хэлэлцэх асуудалтай холбоотой зөвлөмж гарган ТУЗ-д танилцуулж ажилладаг.

Дотоод аудитын хороо

Дотоод аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, аудитын байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хорооны гишүүд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүн: Б.Ганбат, Г.Уянга

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн: В.Ганзориг, Б.Солонго, С.Энхчимэг

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гол зорилго нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын бодлогыг тодорхойлох асуудлыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр ТУЗ-ийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслахад оршдог.

Хорооны гишүүд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүн: О.Одбаяр, Г.Уянга, Б.Ганбат

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн: В.Ганзориг, Б.Солонго

Санхүү, эрсдэл, зээлийн хороо

Санхүү, эрсдэл, зээлийн хороо нь компанийн стратеги төлөвлөгөө, санхүү, зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлогыг боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулах, компанийн хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, зээлийн эрсдэлийг бууруулахад хяналт тавьж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хорооны гишүүд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүн: О.Одбаяр, Б.Золбоо, Г.Тэлмэн

Эдийн засгийн орчин

Эдийн засгийн орчин

2022 онд хил боомтын саатал, ОХУ-Украины дайны нөлөөтэй холбоотойгоор уул уурхайн салбар өмнөх онтой харьцуулахад 11.9%-ийн уналттай гарсан ч уул уурхайн бус салбар илүү өсөлттэй гарснаар манай улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр буюу 4.8%-тай гарлаа.

Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуй 12.0%, бүтээгдэхүүний цэвэр татвар 11.5%, бөөний болон жижиглэн худалдаа 8.0%, боловсруулах үйлдвэрлэл 6.3%, үйлчилгээний салбар 4.9%-иар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Инфляц

2022 онд инфляц улсын хэмжээнд 13.2%-д хүрч өмнөх оноос 0.2%-иар буурсан хэдий ч Монголбанкны зорилтот түвшнээс өндөр түвшинд хадгалагдав. Инфляцад ханшийн өөрчлөлт, гадаад орчинд бий болсон тодорхой бус байдал, түүнтэй холбоотой зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөө өндөр хэвээр байлаа.

Эх сурвалж: Монголбанк

Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2022 оны эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 29.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 (6.4%) их наяд төгрөгөөр өсөхөд валютын харилцах 2.6 (2.1 дахин) их наяд төгрөгөөр, валютын хадгаламж 936.9 (23.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Мөн, 2022 онд Монголбанкнаас инфляцыг зорилтот түвшинд барихын тулд мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлж бодлогын хүүг 5 удаа нийт 7%-иар нэмэгдүүлж 13.0%-д хүргэсэн.

Төрөөс мөнгөний хатуу бодлого баримталсантай холбоотойгоор банкны төгрөгийн зээлийн дундаж хүү 15.3%, долларын зээлийн дундаж хүү 10.5%-д хүрч, өмнөх оны мөн үеэс харгалзан 0.8%, 2.2%-иар нэмэгдсэн бол нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны эцэст 22.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (6.5%) их наяд төгрөгөөр өссөн байна.
Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2022 оны 12 дугаар сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 54.3 (2.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.1 хувийг эзэлж байна.

Харин, хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2022 оны эцэст 36,176.8 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 5,492.0 нэгжээр буурсан бол хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 6.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 909.3 (13.2%) тэрбум төгрөгөөр өсжээ.

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД:

КРЕДИТ
ББСБ

Хүчтэй. Хамтдаа.